



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.12.11 № 454
танай _____-ны № _____-т

“ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Л.ТАМИР ТАНАА

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүллээ.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



009030628



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ХӨНДЛӨНГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АЛДАА, ЗӨРЧИЛ ДАВТАГДАН ГАРСАН БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН»
ОНӨААТУГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

АУДИТЫН КОД: ДАА-2024/35-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дархан-Уул аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр
Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер У.Батсүрэн
Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор С.Санжаажав
Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn
Ахлах аудитор С.Батцэцэг
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор Ч.Гантулга
Утас: 70378845 Цахим хаяг: gantulgach@audit.gov.mn
Аудитор Г.Батмягмар
Утас: 70378845 Цахим хаяг: batmyagmarb@audit.gov.mn
Аудитор Н.Отгонцэцэг
Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn
Аудитор Э.Одгэрэл

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:	5
БҮЛЭГ 1. БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМД ЗААСАН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН Ч ТАЙЛАГНАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	6
1.1. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үр дүнтэй хийж гүйцэтгэсэн ч тайлагнал хангалтгүй байна	6
1.2. Байгууллагын дотоод хяналт хангалтгүйгээс хөндлөнгийн хяналт шалгалтаар алдаа, зөрчил давтагдан гарсан байна	8
БҮЛЭГ 2. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ Ч ХӨРӨНГИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛЖЭЭ ...	10
2.1. Орлогыг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс 86.6-287.5 хувиар давуулан биелүүлсэн гэж тайлагнасан байна	10
2.2. Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулсан байна	12
БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА	15
3.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа ижил төстэй ажлын төсөөт өртгийг хувааж төлөвлөсөн нь хуульд нийцэхгүй байна	15
3.2. Иргэдийн чөлөөт цаг, бие бялдраа хөгжүүлэх таатай орчныг бий болгосон байна	17
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	19
ЗӨВЛӨМЖ:	19

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГАУ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДХСА	
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ТАГ	Төрийн аудитын газар
ТҮЦ	Түргэн үйлчилгээний цэг
ШТА	Шууд тайлагнах аудит
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүл, хамгаалал хөгжлийн газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан байдал	4
Хүснэгт 2	Тоглоомын үнэ тогтоосон байдал	8
Хүснэгт 3	Тоглоомын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 4	Түрээсийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	10
Хүснэгт 5	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулсан судалгаа	10
Хүснэгт 6	ОНХС, ОНТХО-аарх хөрөнгийн санхүүжилт	15

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Үндсэн хөрөнгийн дансаар ангилан харуулсан байдал	16

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	“Дархан-50” цогцолборын гэрэлтүүлэг, тохижилт	6
Зураг 2	“Миний монгол цэцэрлэгт хүрээлэн”-ийн гэрэлтүүлэг, тохижилт	6
Зураг 3	Кассын байр бүтээн байгуулсан байдал	13
Зураг 4	AR тоглоомын төвийн гадна фасадын ажил хийсэн байдал	14
Зураг 5	Ангилан ялгах хогийн цэг байгуулсан байдал	14
Зураг 6	Гэрэлт гудамж байгуулсан байдал	14

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3 заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Тус байгууллагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Орлогын төлөвлөгөөг биелүүлж, хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалт болон хөрөнгийн ашиглалт үр дүнтэй байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын 2022-2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн баримт материал, тушаал шийдвэр холбогдох бусад материалыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, МҮЕА-ын 2020 оны А/106 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 тоот тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"

- Дархан сумын ИТХ-ын 2022 оны 15 дугаар тогтоол
- Байгууллагын 2022, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
- Байгууллагын дүрэм
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

**Аудит хийсэн багийн
бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер У.Батсүрэн хэрэгжүүлэн ахлах аудитор С.Санжаажав, С.Батцэцэг, аудитор Ч.Гантулга, Н.Отгонцэцэг, Г.Батмягмар, Э.Одгэрэл нар 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

**Аудитад учирсан
хүндрэл бэрхшээл**

Аудитыг хийж гүйцэтгэхэд хүндрэл бэрхшээл гараагүй болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Нийтийн аж ахуй үйлчилгээний газрыг үйл ажиллагааны чиглэлээр нь 2 салгаж "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ийг байгуулжээ. Тус соёл амралтын хүрээлэн нь "Дархан-50" цогцолбор, "Морин хуур" цогцолбор, "Миний монгол цэцэрлэгт хүрээлэн", "Бурхантай-Уул", "Сүрэнгийн гудамж", "Дүүжин гүүр", "Хөл бөмбөгийн талбай" зэрэг байгууламжийн гэрэлтүүлэг, тохижилт, арчлалт хамгаалалтыг дангаар хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд нийт 49 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллага нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө" боловсруулах загварын дагуу 2022, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг тайлагнадаг байна.

БҮЛЭГ 1. БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМД ЗААСАН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН Ч ТАЙЛАГНАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үр дүнтэй хийж гүйцэтгэсэн ч тайлагнал хангалтгүй байна

Байгууллагын зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын дүрэмд заасан үндсэн чиглэлд уялдуулан төлөвлөж, батлуулжээ.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ийн 2022, 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг аймгийн Засаг дарга болон Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Олон Улсын стандартад нийцсэн Хөл бөмбөгийн талбайг ашиглалтад оруулна”, “Явган хүний зам болон унадаг дугуйн замыг стандартад нийцүүлэн байгуулна”, “Хороолол доторх болон гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ”, “Цэвэр хот” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ”, “Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ” зэрэг арга, хэмжээтэй уялдуулан төлөвлөжээ. Тухайлбал:

Хүснэгт №1. Хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан байдал

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын арга хэмжээний нэр	Арга хэмжээний тоо		Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиглэл	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиглэл
	2022 он	2023 он		
Зорилго 1. Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, хамгаалалт, тордолтыг байнга, тасралтгүй, чанартай хийнэ.	12	18	1.2.3.2, 1.2.3.3,	1.2.1.1, 1.2.3.4, 1.5.4.4, 3.4.3.1, 4.2.2.3,
Зорилго 2. Хот доторх ногоон байгууламжийн үйлчилгээг өндөр бүтээмжтэйгээр хийж гүйцэтгэнэ.	9	10	4.2.2.2, 4.2.2.3	2.7.2.13, 4.2.2.4,
Зорилго 3. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлуудыг техник технологийн дэвшлийг ашиглан чанартай хийж гүйцэтгэнэ	3	2	2.4.1.2	1.5.4.4, 2.5.1.3
Зорилго 4. Хөдөлгөөнт тоглоомын төвийн үйл ажиллагааг бүс нутагтаа тэргүүлэх хэмжээнд явуулна.	4	10		
Зорилго 5. Борлуулалтын орлогоо нэмэгдүүлж, улирлын хэлбэлзлийг багасгах чиглэлд санаачилгатай ажиллана.	6	9		
Нийт арга хэмжээний тоо	34	49		

Эх сурвалж: Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

Мөн байгууллагын дүрмээр баталсан үйл ажиллагааны үндсэн чиглэл, дэвшүүлсэн зорилго, зорилтуудад уялдуулан төлөвлөжээ.

Эрх бүхий байгууллага төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэхгүй байгаагаас гүйцэтгэлийг бодитой тайлагнахгүй байна.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь “Дархан-50” цогцолбор, “Морин хуур” цогцолбор, “Миний монгол цэцэрлэгт хүрээлэн”, “Бурхантай-Уул”, “Сүрэнгийн гудамж”, “Дүүжин гүүр”, “Хөл бөмбөгийн талбай” зэрэг байгууламжийн гэрэлтүүлэг, тохижилт, арчлалт хамгаалалтыг дангаар хариуцан

хэрэгжүүлдэг бөгөөд 2022 онд төлөвлөсөн 34 арга хэмжээний хэрэгжилтийг 100.0 хувиар, 2023 онд төлөвлөсөн 49 арга хэмжээний хэрэгжилтийг 98.4 хувиар тус тус тайлагнасан байна.

Аудитаар байгууллагын 2022, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нийт 83 арга хэмжээнээс түүвэрт хамрагдсан 38 арга хэмжээний хэрэгжилтийг тулган шалгахад “бүрэн хэрэгжсэн” 33, “дутуу хэрэгжсэн” 5 арга хэмжээ байна. Үүнээс:

➤ “Худалдаа наймаа эрхлэгчид болон үйлчлүүлэгч иргэдийн сэтгэл ханамжийг өндөр байлгахад чиглэж ажиллана” гэсэн арга хэмжээнд сэтгэл ханамжийн судалгаа, шинжилгээ байхгүй,

➤ “Хөдөлгөөнт тоглоомын үйлчилгээний чанар, хүртээмж сайжирснаар бусад орон нутгийн болон гадаад иргэдийн үйлчлүүлэх тоо нэмэгдэнэ” гэсэн арга хэмжээний тоон мэдээлэл, хэрэгжилт нотлогдохгүй,

➤ “Байгууллагаараа 7 хоног бүр спортоор хичээллэх заал авах үйл ажиллагааг зохион байгуулах” гэх арга хэмжээг 1 улирал зохион байгуулсан зэргээс шалтгаалан арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байхад гүйцэтгэлийн тайланд 100 хувь хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланд арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тусгаагүй, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг төлөвлөсөн арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж, тайлагнаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох тайлан гаргах журам”-ын 2.4.4¹ дэх заалттай нийцэхгүй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Дархан сумын Засаг даргын 2022 оны Б/87, 2023 оны Б/66 дугаар захирамжид “Маш сайн” гэж үнэлсэн боловч арга хэмжээ бүрээр хийсэн үнэлгээний нотлох баримтыг ирүүлээгүй нь “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ийн дүрмийн 7.7-д “Сумын Засаг даргын Тамгын газар нь тус үйлдвэрийн газрыг удирдлага аргагүйгээр хангаж, ажлын үр дүнг үнэлж дүгнэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд байгууллагын дүрэмд заасны дагуу, ажлын үр дүнг арга хэмжээ бүрээр дүгнэж, ажлын үр дүнг бодитой үнэлснээр зорилтот түвшиндээ хүрснийг үнэлгээгээр баталж, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт хангагдана.

Гэсэн хэдий ч “Миний монгол цэцэрлэгт хүрээлэн”, “Дархан-50” цогцолборын явган хүний болон дугуйн зам, нийтийн ариун цэврийн байр, камержуулалт, гэрэлтүүлэг, ундны усны зориулалтын цэг шинээр байгуулсан зэрэг олон тохижилтын ажлуудыг хийснээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, орчин нөхцөл бүрдсэн байна.

¹ “Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх”;

Зураг №1: "Дархан-50" цогцолборын гэрэлтүүлэг, тохижилт



Зураг №2: "Миний монгол цэцэрлэгт хүрээлэн"-ийн гэрэлтүүлэг, тохижилт



Мөн ашиглагдахгүй байгаа объектыг 3 тасалгаа бүхий хогийн сав болгон тохижуулж ангилан ялгах хогийн цэг байгуулан, хуванцар савыг борлуулснаар өөрийн орлогыг нэмэгдүүлж байгаа нь сайшаалтай арга хэмжээ болжээ.

1.2. Байгууллагын дотоод хяналт хангалтгүйгээс хөндлөнгийн хяналт шалгалтаар алдаа, зөрчил давтагдан гарсан байна

Газрын даргын тушаалаар батлагдсан дотоод хяналт шалгалтын баг журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг үндэслэн газрын даргын 2023 оны А/09 дүгээр тушаалаар "Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүн, дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг баталсан ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд холбогдох дүрэм, журамд заасны дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллах шаардлагатай байна.

Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил давтагдан гарсаар байна.

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 64,036.4 мянган төгрөгийн 32 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бараа материал дансаар дамжуулан шууд зардалд бүртгэсэн, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 5,662.9 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй, 3,048.4

мянган төгрөгийн түрээсийн орлогыг дутуу тайлагнасан, тооцсон цалингаас 387.3 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ыг дутуу суутгасан зэрэг зөрчлүүд гарсан бол 2023 онд үндсэн хөрөнгийн бүртгэл, ангилал, элэгдэл зардлыг буруу бүртгэсэн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлээгүй, НДШ-ийг зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн бүртгэл, ангилал, элэгдэл зардлыг буруу бүртгэснээс 144,609.1 мянган төгрөгийн,
- НДШ-ийг зөрүүтэй тайлагнаснаас 5,294.7 мянган төгрөгийн,
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлээгүйгээс 30,103.4 мянган төгрөгийн,
- Кассын тайланд туслах үйл ажиллагааны орлогыг бүртгэлгүйгээр шууд банканд тушаасан зэрэг зөрчлүүдийг гаргасан байна.

Мөн сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгосон, тооллогын комисс байгуулаагүйгээс эхний хагас жилийн тооллогыг зохион байгуулаагүй, орон тоог зөв төсөвлөн батлуулаагүй зэрэг нийт 181,042.2 мянган төгрөгийн 10 зөрчил гаргасан байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн биелэлтийг цахим систем болон байгууллагын үйл ажиллагаанд биет шалгалт хийхэд хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд хийсэн шалгалтаар байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон бусад баримт бичигт дотоод хяналтыг хэн хийх, хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй, хөдөлмөрийн дотоод журмыг ажил олгогч батлаагүй зэрэг зөрчилд зөвлөмж өгч, түрээсийн гэрээний хэрэгжилт хангалтгүйгээс 3,048.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй зөрчилд албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчил давтан гарч байгаа нь байгууллагын удирдлагын болон дотоод хяналт хангалтгүй байгаагаас гадна санхүүгийн ажилтны мэдлэг чадвар, ажлын туршлага, хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

БҮЛЭГ 2. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ Ч ХӨРӨНГИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛЖЭЭ

2.1. Орлогыг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс 86.6-287.5 хувиар давуулан биелүүлсэн гэж тайлагнасан байна

Хүүхдийн тоглоомын үнэ тарифыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулсан боловч үнэ тариф тогтооход ашигласан тоо баримт, тооцоо судалгааг аудитын багт ирүүлээгүй болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10² дахь хэсэгт заасны дагуу Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2020 оны 16/04 дүгээр тогтоолоор Нийтийн аж ахуйн үйлчилгээний газрын хөдөлгөөнт тоглоомоор иргэдэд үйлчилгээ үзүүлэх үнэ тариф баталсныг үйл ажиллагааны чиглэлээс хамаарч 2 салгаж, тус газрыг байгуулсантай холбоотой Дархан сумын ИТХ-ын 2023 оны 04 дүгээр тогтоолоор үнэ тарифыг шинэчлэн тогтоожээ.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь “Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн”-д ажиллуулж байгаа 7 хөдөлгөөнт тоглоомтой бөгөөд үнийг 3.0-4.0 мянган төгрөг, хугацааг 3-15 минут байхаар тогтоосон байна. Тоглоом тус бүрийн үнэ тариф, хугацааг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №2: Тоглоомын үнэ тогтоосон байдал

№	Тоглоомын төрөл	Үнэ тариф				Зөрүү	
		Аймгийн ИТХ-ын 2020 оны 16/04 тогтоолоор		Дархан сумын ИТХ-ын 2023 оны 04 дүгээр тогтоол		Хугацаа /Минут/	Нэг удаа тоглох үнэ /Төгрөг/
		Хугацаа /Минут/	Нэг удаа тоглох үнэ /Төгрөг/	Хугацаа /Минут/	Нэг удаа тоглох үнэ /Төгрөг/		
1	Морин тойруулга	3	3,000	3	3,000	-	-
2	Кофейны аяга	3	3,000	3	3,000	-	-
3	Гинжит савлуур	3	4,000	4	4,000	1	-
4	Далайн дээрэмчин савлуур	3	3,000	4	4,000	1	1,000
5	Уран жолоодлогын машин	3	4,000	5	4,000	2	-
6	Агаарын дугуй	5	4,000	5	4,000	-	-
7	Алсыг харагч	15	4,000	15	4,000	-	-

Эх сурвалж: “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын санхүүгийн баримт

Дээрх хүснэгтээс харахад 3 тоглоомын хугацаанд 1-2 минут нэмж, үнэ тарифт өөрчлөлт оруулаагүй байна.

Аудитаар хүүхдийн паркт аймга, Улаанбаатар хотын Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн тоглоомын үнэ тарифыг судлахад нэг удаа тоглох үнэ орон нутагт 2.5-7.0 мянган төгрөг, Улаанбаатар хотод 6.0-8.0 мянган төгрөг байна.

Харьцуулсан судалгаанаас харахад хүүхдийн тоглоомын тогтоосон үнэ тариф дунджаас 0.6 мянган төгрөгөөр доогуур байна.

Хүүхдийн тоглоомын орлогыг үндэслэлтэй тооцож төлөвлөгөөгүй байна.

² хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

Дархан сумын Засаг дарга "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ын орлогын төлөвлөгөөг жил бүр баталдаг бөгөөд 2022-2023 онд орлого 86.6-124.6 хувиар давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3: Тоглоомын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Тоглоомын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зөрүү
		Мөнгөн дүн	Мөнгөн дүн	Хувь	
2022 он	Тоглоомын орлого	150,000.0	336,936.9	224.6	186,936.9
	Дүн	150,000.0	336,936.9	224.6	186,936.9
2023 он	Тоглоомын орлого	221,000.0	414,244.8	187.4	193,244.8
	AR тоглоом	12,000.0	20,609.2	171.7	8,609.2
	Дүн	233,000.0	434,854.0	186.6	201,854.0

Эх сурвалж: "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ын санхүүгийн баримт

Дээрх хүснэгтээс харахад орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх оны гүйцэтгэл, тооцоололд үндэслэн төлөвлөөгүй байна

Аудитаар тоглоомын орлогыг холбогдох дансанд бүрэн төвлөрүүлж чадаж байгаа эсэхийг анхан шатны баримт руу хөөн шалгахад албан тушаалтнуудын ажилдаа хариуцлагагүй хандсанаас тоглоомын тасалбарт огноо, дугаарыг бичиж тэмдэглээгүй, тасалбарыг орлого, зарлагаар бүртгэж, бараа материалын тайланд тайлагнаагүй, архивын нэгж болгоогүй байна. Энэ нь орлогын тулгалт хийх боломжгүй байдалд хүргэсэн бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1³, 13.7⁴, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2.4⁵-д заасантай нийцээгүй бөгөөд орлогыг дутуу илэрхийлэх, залилан мэхлэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, албан тушаалтан хариуцлага хүлээх эрсдэлтэй.

Иймд хүүхдийн тоглоомын тасалбарыг дугаарлах, огноог бичиж тэмдэглэх, тасалбарыг бараа материалын дансаар дамжуулах байдлаар шат шатны хяналтыг сайжруулах, орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тооцоололд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.

Түрээсийн болон бусад орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй тооцож төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө 287.5 хувиар давж биелсэн байна.

Дархан сумын ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор түрээсээр үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгжийн түрээсийн үнэ тарифыг үйлчилгээний төрөл, байршил зэргээс хамаарч 20.0-300.0 мянган төгрөгөөр баталжээ.

Дархан сумын Засаг даргаар батлуулсан орлогын төлөвлөгөөнд 2022 онд орлого огт төлөвлөөгүй байсан бол 2023 онд түрээсийн орлогыг төлөвлөж, бусад орлогыг төлөвлөөгүй байна. Гэвч гүйцэтгэлээр түрээсийн болон бусад орлогоос 2022 онд 28,484.6 мянган төгрөг, 2023 онд 65,880.0 мянган төгрөгийн орлого олсон байна.

Түрээсийн болон бусад орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4: Түрээсийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

³ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁵ гадаад харилцаа, хамтын ажиллагаа, татвар, санхүү, хүний нөөц.

Үзүүлэлт	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зөрүү
		Мөнгөн дүн	Мөнгөн дүн	Хувь	
2022 он	Түрээсийн орлого	-	26,644.6	-	26,644.6
	Бусад орлого	-	1,840.0	-	1,840.0
	Дүн	-	28,484.6	-	28,484.6
2023 он	Түрээсийн орлого	17,000.0	44,000.0	258.8	27,000.0
	Бусад орлого	-	21,880.0	-	21,880.0
	Дүн	17,000.0	65,880.0	387.5	48,880.0

Эх сурвалж: “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын санхүүгийн баримт

Орлогыг өнгөрсөн жилийн гүйцэтгэлээс бууруулж баталсан нь аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оныг жижиг дунд, бизнесийг дэмжих жил болгон зарласан тул худалдаа үйлчилгээ эрхэлдэг хувь хүн, аж ахуйн нэгжийн түрээсийн төлбөрийг хүйтний улирал, Хүүхдийн баяр, Улсын Баяр наадмаар худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн түрээсийн төлбөрийг тэглэсэнтэй холбоотой байна.

Төлөвлөж батлаагүй бусад орлогоор 2022 онд мал хашсаны орлого 1,800.0 мянга, хуванцар хаягдал хогыг тушаан 40.0 мянга, нийт 1,840.0 мянган төгрөгийн орлого оруулсныг өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөх боломжгүй орлого тул 2023 онд бусад орлогоор орлогын төлөвлөгөө гаргаж батлуулаагүй боловч гүйцэтгэлээр био нойлын түрээс, мал хашсан, хуванцар хог хаягдал тушааснаас 21,880.0 мянган төгрөгийн орлого оржээ.

2.2. Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Үйл ажиллагааны зардлыг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь 2022 оны үйл ажиллагааны зардлыг 600,398.7 мянга, 2023 оны үйл ажиллагааны зардлыг 750,399.8 мянган төгрөгөөр тус тус тооцож, төлөвлөснийг Дархан сумын Засаг дарга хэвээр баталсан байна.

Хүснэгт №5: Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулсан судалгаа /мян.төг/

Зардлын нэр төрөл	2022 он			2023 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,636.0	285,873.1	3,237.1	420,143.2	417,358.6	(2,784.6)
Ажил олгогчоос төлөх НДШ	38,155.9	38,155.9	-	52,167.8	52,167.8	-
Байр ашиглалттай холбоотой зардал	39,914.7	35,653.9	(4,260.8)	59,223.0	58,995.9	(227.1)
Хангамж, бараа материалын зардал	16,650.1	14,399.4	(2,250.7)	13,483.0	13,049.7	(433.3)
Урсгал засварын зардал	100,304.0	79,889.2	(20,414.8)	144,881.8	119,078.5	(25,803.3)
БГАҮ-ний төлбөр	47,239.4	36,051.0	(11,188.4)	53,301.0	53,083.4	(217.6)
Бараа, үйлчилгээний бусад зардал	59,898.6	18,698.2	(41,200.4)	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг	15,600.0	13,209.5	(2,390.5)	7,200.0	7,103.4	(96.6)
Дүн	600,398.7	521,930.2	(78,468.5)	750,399.8	720,837.3	(29,562.5)

Эх сурвалж: Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан Дархан сумаас олгох санхүүжилтийн 10 хувийг үлдээж, 2022 онд 540,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ.

Тус газрын 2022 оны зардлын гүйцэтгэл 521,930.2 мянган төгрөг буюу 86.9 хувьтай гарсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байна.

Харин цалингийн зардал 3,237.1 мянган төгрөгөөр хэтэрсэн нь Улсын баяр наадмыг анх удаа “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд тэмдэглэхтэй холбогдуулан албан хаагчид илүү цагаар ажилласнаас шалтгаалжээ.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-т 2023 онд орон нутгийн төсвөөс 721,946.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 720,837.3 мянган төгрөгийг зарцуулж, 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Иймд “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөсөн байна гэж дүгнэлээ.

Тус газар нь орон нутгийн төсвөөс 1,261,946.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын нийт зардлын 62.1-65.1 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд, 6.8-8.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 1.8-2.8 хувийг хангамж бараа материалын зардалд, 15.3-16.5 хувийг урсгал засварын зардалд, 6.9-7.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 1.0-2.5 хувийг бусад урсгал шилжүүлгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Аудитаар харилцах дансны зарлагын 1,457 гүйлгээнээс МҮЕА-ын 2018 оны А/151 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу 90 хувийн баталгааны түвшинд 2.5 хувийн алдааны хязгаарт түүврийн хэмжээг тооцоолон 620 гүйлгээг шалгалаа. Тооцоолсон түүврээс 10.0 сая төгрөгөөс дээш 48 гүйлгээг дангаараа нөлөө бүхий зүйлс гэж авч үзэн, үлдсэн 572 гүйлгээг random программаар сонгов.

Зардлын гүйцэтгэлийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус байгууллагын дарга эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 3,788.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлс, 1,056.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсан.
- ОНӨААТҮГ-ын даргын Дархан сумын засаг даргатай байгуулсан хөдөлмөрийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан гэрээний загварын дагуу хийгээгүй.
- Түүвэрт хамрагдсан 620 гүйлгээнээс 73,062.0 мянган төгрөгийн 96 гүйлгээ нь цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй байна.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь 2022-2023 онд орон нутгийн төсвөөс 1,261,946.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан ба өөрийн орлогоор 997,696.7 мянган төгрөгийн орлого олсноос үйл ажиллагааны зардалд 1,779,318.0 мянга, хөрөнгийн зардалд 479,549.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үүнээс харахад хөрөнгийн зардлыг бусад эх үүсвэрээр буюу орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн эх үүсвэрээр санхүүжүүлбэл үйл ажиллагааны зардлын 50 гаруй хувийг өөрийн орлогоор санхүүжүүлэх боломжтой байна.

ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж,

бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд цаашид үйл ажиллагааны зардлыг өөрөө санхүүжүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжих нөөц боломжийг судлан, хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА

3.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа ижил төстэй ажлын төсөвт өртгийг хувааж төлөвлөсөн нь хуульд нийцэхгүй байна

Ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хувааж төлөвлөсөн нь хуульд нийцэхгүй байна.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь орон нутгийн төсвийн санхүүжилтээр 2022 онд 353,500.0 мянган төгрөгийн 37, 2023 онд 197,707.8 мянган төгрөгийн 17 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж батлуулснаас гадна 2023 оны 10 дугаар сард байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай засвар, үйлчилгээнд 280,000.0 мянган төгрөгийн 11 бараа, ажил, үйлчилгээг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр нэмж батлуулжээ.

Аудитаар Төрийн худалдан авах цахим системд www.tender.gov.mn худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөөг ил тод, нээлттэй байршуулсан эсэхийг тулгахад тус газар нь 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулагдсан тул 2022 оны худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөөг байршуулаагүй бол 2023 оны төлөвлөгөөг худалдан авах ажиллагааны цахим системд хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Тус байгууллага ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д заасныг баримтлаагүйгээс шууд худалдан авалт хийх зорилгоор нийт 122,970.0 төгрөгийн ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг 8 арга хэмжээнд хуваан төлөвлөж, шууд гэрээ байгуулжээ.

Иймд цаашид худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа ижил төстэй бараа, ажил үйлчилгээг багцалж төлөвлөн, худалдан авалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

Худалдан авсан бараа, материалаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулсан хэрэгцээ шаардлагад нийцсэн олон бүтээн байгуулалт хийсэн байна.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор худалдан авах бараа, ажил, үйлчилгээг жил бүр төсөвлөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллажээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2022 онд 325,765.7 мянга төгрөгийн 37, 2023 онд 153,783.9 мянган төгрөгийн 17, нийт 479,549.6 мянган төгрөгийн 54 нэр төрлийн тоног төхөөрөмж, бараа, материал худалдан авч, өөрсдийн дотоод нөөц бололцоо, ажилтан, албан хаагчдын ур чадвар, боломжид тулгуурлан бүтээн байгуулалтаа хийжээ. Бүтээн байгуулалтаас дурдвал:

Зураг №3: Кассын байр бүтээн байгуулсан байдал



Зураг №4: AR тоглоомын төвийн гадна фасадын ажил хийсэн байдал



Зураг №5: Ангилан ялгах хогийн цэг байгуулсан байдал



Зураг №6: Гэрэлт гудамж байгуулсан байдал



Дээрх засвар шинэчлэлийн ажлуудыг хийснээр байгууллагын зорилго, зорилт хангагдаж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэнээс гадна иргэдийн тав тухтай, эрүүл, аюулгүй орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг бүрдүүлсэн үр дүнтэй ажлууд болсон байна.

Харин 2022 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авсан 9,000.0 мянган төгрөгийн 6 автомат кассын машиныг 8,783.5 мянга, 90,000.0 мянган төгрөгийн төсөвт өртгөөр бий болгосон “AR” тоглоомын төвийг 72,869.2

мянган төгрөгөөр завсар, үйлчилгээ хийж ашиглалтад оруулсан хэдий ч зориулалтын дагуу ашиглаагүй байв.

Автомат кассын машиныг 2022 онд туршилтаар түр хугацаанд хэрэглэж байсан бөгөөд 1,000 төгрөгийн дэвсгэртээс бусад дэвсгэрт таних боломжгүй тул дахин ашиглаагүй байна.

Харин орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, өвлийн улиралд орлого олох зорилгоор байгуулсан АР тоглоомын төвийг өөрсдийн байргүйн улмаас одоогоор байгууллагын оффис болгон ашиглажээ.

Иймд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, худалдан авах, ашиглалт, хамгаалалтыг сайжруулахад байгууллагын удирдлага анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.2. Иргэдийн чөлөөт цаг, бие бялдраа хөгжүүлэх таатай орчныг бий болгосон байна

Хөрөнгө оруулалтаар бий болсон 55 төрлийн 3,807,584.9 мянган төгрөгийн хөрөнгийн хүлээн авсан нь хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-т 2022-2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 3,807,584.9 мянган төгрөгийн 55 нэр төрлийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тогтоолоор шилжүүлэн өгснийг бүртгэл, тайланд тусгажээ.

Хүснэгт №6: ОНХС, ОНТХО-аарх хөрөнгийн санхүүжилт

Хөрөнгө оруулалтын нэр	2022 он		2023 он	
	хөрөнгийн төрөл	мөнгөн дүн /мян.төг/	хөрөнгийн төрөл	мөнгөн дүн /мян.төг/
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	38	1,893,343.7	5	658,720.0
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	2	22,312.6	10	1,233,208.6
Нийт дүн	40	1,915,656.3	15	1,891,928.6

Эх сурвалж: "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ

Дээрх хөрөнгө оруулалтаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн нийтийн эзэмшлийн агаарын дугуйн зам, хүүхдийн тоглоомын цогцолбор, ногоон төгөл, явган хүний болон дугуйн зам, сагсан бөмбөг, волейболын талбай, лэд дэлгэц, гэрэлтүүлэг "Миний монгол цэцэрлэгт хүрээлэн"-ийн гадна хашааг барих зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг хийсэн байна.

Аудитаар дээрх бүтээн байгуулалтын ажлын үр дүнг google form ашиглан 65 иргэнээс 6 асуулт бүхий санал асуулга авч нэгтгэлээ. Санал асуулгад хамрагдсан иргэдийн 93 хувь нь эрүүл аюулгүй орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчин бүрдсэн гэсэн эерэг үнэлгээ өгсөн байна.

Мөн ОНТХО-аар байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд ашиглах 103,110.0 мянган төгрөгийн 13 нэр төрлийн хөрөнгийг хүлээн авсан байна. Тухайлбал:

- Олон үйлдэлт трактор BOBCAT S18,
- Бага оврын ачааны 2 авто машин,
- Хэвлэлийн тоног төхөөрөмж,
- Контейнер, хогийн сав,

- Чанга, нам яригч, чадлын өсгөгч, дууны процессор, утасгүй микрофон, видео дууны процессорууд байна.

Аудитаар эдгээр хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтыг шалгахад байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд зориулалтаар нь ашиглаж байна.

Байгууллагад бүртгэлтэй үндсэн хөрөнгийг зориулалтаар нь ашиглаж байна.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 34,723,562.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тайлагнасан байна. Үүнээс 2022-2023 онд 341,938.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Дүрслэл №1: Үндсэн хөрөнгийн дансаар ангилан харуулсан байдал



Батлагдсан төсвөөр 2022 онд 169,241.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн бол 2023 онд 135,692.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 37,003.3 мянган төгрөгийн бараа материалаар харуулын болон кассын байр, гэрэлт гудамж байгуулан, шинээр нэмэгдсэн хөрөнгийг санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна.

Эх сурвалж: “ДХСАХ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан

Аудитаар шинээр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг байгууллагын хөрөнгийн бүртгэлтэй тулган, машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг шалгахад байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад 341,938.0 мянган төгрөгийн, иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх, нийтийн эзэмшлийн 3,807,584.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус ашиглалтад оруулан, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитаар нийт 77,906.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 1,056.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдаа, зөрчлийг таслан зогсоох 3,788.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 73,062.0 мянган төгрөгийн 9 зөвлөмж хүргүүллээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үр дүнтэй хийж гүйцэтгэсэн ч тайлагнал хангалтгүй, хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.
- Байгууллагын дотоод хяналт хангалтгүйгээс хөндлөнгийн хяналт шалгалтаар алдаа, зөрчил давтагдан гарсан байна
- Тоглоомын орлогод бүртгэлээр тавих хяналт хангалтгүйгээс орлого тасалдах, дутагдах эрсдэлтэй байна.
- Үйл ажиллагааны орлогыг тооцоололд үндэслэн төлөвлөөгүй ч санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулсан байна
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд нийцүүлэн боловсруулаагүй, төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн байна
- Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, иргэд чөлөөт цагаа өнгөрөөх, тав тухтай орчин бүрдүүлсэн үр дүнтэй бүтээн байгуулалтууд болсон байна

ЗӨВЛӨМЖ:

Дархан сумын ЗДТГ-ын дарга Б.Батзулд зөвлөх нь:

- Байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга зүйн зөвлөгөө өгч, арга хэмжээ бүрээр үнэлж, дүгнэх

"Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ийн дарга Тамирт:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаж, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг төлөвлөсөн арга хэмжээтэй уялдуулан тайлагнах
- Газрын даргын тушаалаар баталсан "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах
- Тоглоомын тасалбарыг дугаарлах, огноог бичиж тэмдэглэх, тасалбарыг бараа материалын дансаар дамжуулах байдлаар шат шатны хяналтыг сайжруулах
- Хүүхдийн тоглоомын орлогыг тооцоололд үндэслэн төлөвлөх
- Түрээсийн болон бусад орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тооцоололд үндэслэн төлөвлөх

- Бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх
- Газрын даргын хөдөлмөрийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан гэрээний загварын дагуу шинэчлэн байгуулах
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд нийцүүлэн боловсруулах

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁶-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2024.12.11

⁶ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

